



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/3/СТА-ТТЗ

<p>Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: bunkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
-----------------------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	7
2.8.2 Авлага	8
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	10
Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	13
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
2.12. Шилэн дансны мэдээлэл	13
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
1. Менежментийн захидал	14
3.1 .Харьяа төсөвт байгууллагатай холбоотой зөрчлийн талаар.	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	25
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА Т
Р.ЖАМЪЯНДОРЖ ТАНАА

2020 о. 03.25 № 1/368

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

* 005020301

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянбулаг сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. ОРШИЛ

Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Р.Жамъяандорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 11-ноос 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд гүйцэтгэв.

Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 12 дугаар сарын 20 -ны өдөр 133 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.-

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянбулаг сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Баянбулаг сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	2	-
	Дүн	2	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянбулаг сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Баянбулаг сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1668356,3 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 16683,5 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2013808,1 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 20138,1 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 3454,6 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна. Үүнээс:

№	Байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр	Аудитад хийсэн байгууллага нэр
1	ЗДТГ	Хязгаарлалттай	
2	Эрүүл мэндийн төв	Зөрчилгүй	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
3	Ерөнхий боловсролын сургууль	зөрчилгүй	"Глобаль капитал аудит" ХХК
4	Цэцэрлэг	Зөрчилгүй	"Глобаль капитал аудит" ХХК
5	ИТХ	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
6	Соёлын төв		
7	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
8	Сум хөгжүүлэх сан		

Тайлант онд Баянбулаг сумын ЗДТГ нь сум сурталчлах арга хэмжээг Аж ахуй нэгж байгууллагаар гүйцэтгүүлэхээр Засаг даргын Тамгын газрын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ худалдан авах зардлаас 10000,0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, зарцуулалт тодорхойгүй, хэрэгжилтийг тооцоогүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд зөрчсөний улмаас "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.

Баянбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд зөрчил илрээгүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 108,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Төсвийн шууд захирагчийн тайланд илэрсэн алдаа, зөрчил /сая.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс					
				Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ИТХ								
2	ЗДТГ	11	58,6	5	33,9	1	4,8	2	19,9
3	Ерөнхий боловсролын сургууль	1	2,9			1	2,9		
4	Цэцэрлэг	1	0,2	1	0,2				
5	Эрүүл мэндийн төв	3	1,2			1	0,5	1	0,5
6	Соёлын төв	1	0,6			1	0,6	1	2,7
7	Сум хөгжүүлэх сан	3	45,1			1	35,1	1	10,0
8	Орон нутаг хөгжүүлэх сан								
	дүн	21	108,6	10	34,1	5	43,9	5	33,1

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 187512.9 мянга, эцсийн үлдэгдэл 126717.1 мянган төгрөг болж 60795.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эцсийн үлдэгдлийн эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	86201,8	27486,8	-58714,9	21,69%
ОНХС	63195,3	49695,0	11419,5	39,09%
Сум хөгжүүлэх сан	63195,3	49695,0	-13500,3	39,22%
Дүн	187512,9	126717,1	-60795,7	100,0%

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 126717,1 мянган төгрөг нь дээрх харилцах дансанд байршиж байна. Үүнээс Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 27486.8 мянган төгрөгийн үлдэгдлээс 7622,9 мянган төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудад орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн, 19863.9 мянган төгрөг нь урьд оны зарцуулаагүй үлдэгдэл болон тайлант оны татварын орлогоос төвлөрсөн орлого байна.

БНА-2020/3/СТА-ТТЗ

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 143981,2 мянга, эцсийн үлдэгдэл 154090,1 мянга төгрөг болж 10108,9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3079.0	97.4	-2981.6
Байгууллагаас авах авлага	2765.3	1206.4	-1558.9
Зээлийн хүүгийн авлага	138136.9	152786.3	14649.4
Дүн	143981.2	154090.1	10108.9

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оноос 10108.9 мянган төгрөгөөр өссөний гол шалтгаан нь СХС-аас 60490.0 мянган төгрөгийн зээлийн олгосон болон эргэн төлөлттэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийг аудитаар судалж үзэхэд олон жилийн насжилттай сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй хугацаа хэтэрсэн зээлийн авлага 35,1 сая төгрөг байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 144368.3 мянга, эцсийн үлдэгдэл 190333.3 мянган төгрөг болж, 75965.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	28686.4	35524.9	6838.1
Бичиг хэргийн материал	1740.2	3355.3	1615.1
Аж ахуйн материал	21740.8	26626.9	4886.1
Сэлбэг хэрэгсэл		310.0	310.0
Тулш, шатах тослох материал	3580.3	3410.1	-170.2
Хүнсний материал	1301.5	1797.7	496.2
Бусад хангамжийн материал	54877.5	106408.7	51531.2
Мал амьтад	1349.0	450.0	-899.0
Нөөцийн бараа	1092.1	12450.0	11357.9
Дүн	114368.3	190333.6	75965.3

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хандив тусламж, шилжүүлэн авсан 30295.1 мянга, төсвийн хөрөнгөөр 433720.0 мянган төгрөгийн бараа материал авч, 5971,4 мянган төгрөгийн бараа материалыг дотоод шилжүүлгээр гүйлгээ хийж, 382078,2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хүснэгт №3.1 материалын дэлгэрэнгүй /мянган төгрөг/

**Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Д.д	Байгууллага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			хасагдсан			Эцсийн үлдэгдэл
			төсвийн хөрөнгөөр	хандив тусламжаар	дотоод шилжүүлгээр	Зарцуулсан	акталсан	бусад	
1	Сумын ИТХурал	1,046.1	4,289.8	0.0	0.0	4,289.8	0.0	0.0	1,046.1
2	Сумын ЗДТГ	18,899.4	69,958.6	0.0	0.0	51,489.5	0.0	0.0	37,368.4
3	Сумын эмнэлэг	16,980.4	75,613.8	125.0	0.0	75,351.0	0.0	0.0	17,368.2
4	Сургууль	47,551.1	173,552.3	7,900.0	2,541.1	145,660.8	0.0	5,603.4	80,280.3
5	Цэцэрлэг	18,720.6	57,893.9	0.0	19,729.0	63,437.5	0.0	388.0	32,538.0
6	Соёлын төв	11,170.6	39,961.6	0.0	0.0	41,849.6	0.0	0.0	9,282.6
7	ОНХС	0.0	12,450.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	12,450.0
	Дүн	114,368.3	433,720.0	8,025.0	22,270.1	382,078.2	-	5,971.4	190,333.7

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4478426.3 мянга, эцсийн үлдэгдэл 4464915.3 мянган төгрөг болж, 13511.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3347245.0	3362705.0	15460.0
Тээврийн хэрэгсэл	166751.5	183664.4	16912.8
Машин тоног төхөөрөмж	537212.7	495545.7	-41667.1
Тавилга эд хогшил	202405.9	196171.2	-6234.7
Зам гүүрийн байгууламж			
Түүх дурсгалын үнэт зүйлс	931.6	931.6	0
Дуусаагүй барилга, байгууламж			
Номын фонд	27798.9	21943.8	-5855.1
Бусад үндсэн хөрөнгө	145738.1	153391.1	7653.0
Программ хангамж	2880.	3100.0	2200.0
Бусад биет бус хөрөнгө	47462.5	47462.5	0
Дүн	4478426.3	4464915.3	-13511.0

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 108244.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй, хандив тусламжаар 82867.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн мөн 204622.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан зэрэг нь хөрөнгийн үнэ 13511,0 төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Хүснэгт №4.1 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй /мянган төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Төсвийн болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдаж авсан	Үнэ төлбөргүй хандив, тусламжаар авсан	Акталсан	Балансаас баланс-д шилжүүлж өгсөн	Эцсийн үлдэгдэл
Сургууль	835259.7	22905.2	10000.0	62546.7	-	805618.2
Цэцэрлэг	319526.7	7000.0	11297.5	17476.5	-	320347.8
Эрүүл мэндийн төв	1484852.6	17849.0	4000.0	5974.7	-	1431080.3
Соёлын төв	880861.9	362.0	437.0	2817.0	-	886034.9
ИТХ	8900.0		320.0	3706.0	-	8394.0



**Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

ЗДТГ	964899.5	56870.0	50000.0	58329.5	1013440.0
Дүн	4478426.3	108244.2	82867.5	204622.7	4464915.3

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 350.1 мянга, эцсийн үлдэгдэл 353.8 мянган төгрөг болж, 3.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан - үлдэгдэл
Богино хугацаат өр төлбөр дүн	350.1	353.8	3.7
Ажилчидтай холбогдсон өглөг	156.6	21.6	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	159.0	0	-159.0
Байгууллагад төлөх өглөг	34.5	332.2	297.7
Хувь хүмүүст төлөх өглөг			
Нийт дүн	350.1	353.8	3.7

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эхэнд Сургууль 14.4 мянга, ЭМТ 335.7 мянган төгрөгийн бусад байгууллага өглөггүй байсан бөгөөд эдгээр өглөг тайлант онд бүрэн төлөгдсөн байна. Харин оны эцэст ЗДТ 332.2 мянга, ИТХ 16.2 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ.

Хүснэгт 5.1 Өглөгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Төсвийн захирагч	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллага хоорондын
1	Сургууль	14.4			
2	Бага сургууль				
3	Цэцэрлэг				
4	Соёлын төв				
5	ИТХ		16.2	16.2	
6	ЗДТГ		332.2		332.2
7	Эрүүл мэндийн төв	335.7			
8	СХС				
	Дүн	350.1	348.4	172.8	525.7

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо


Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3967662.7 мянга, эцсийн үлдэгдэл 3980519.9 мянган төгрөг болж, 12857.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	1558392.2	1558392.2	0	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	876481.0	876481.0	0	
Хуримтлагдсан үр дүн	1532783.5	1545646.7	12863,2	100
Дахин үнэлгээний нөөц				
Дүн	3967656,7	3980519,9	12863,2	100

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга



Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2018 оны төсөв батлах тухай 10/03 дугаар тогтоолд зааснаар Баянбулаг сумын Засаг дарга тайлант онд татварын орлогоор улсын төсөвт 4100.0 мянга, аймгийн төсөвт 78500.0 мянга, нийт 82600.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 83733.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101,37 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого / мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	4100.	4676.8	576.8	114.06
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1600.0	2066.9	466.9	129.18
1.2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1700.0	2086.2	386.2	122.7
1.3. Агаарын бохирдлын төлбөр	800.0	523.7	-276.3	65.4
2. Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	78500.0	79057.0	557.0	100.0
2.1. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	70000.0	70083.7	83.7	100.1
2.2. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	500.0	785.7	285.7	157.1
2.3. Газрын төлбөр	1800.0	1872.1	72.1	104.0
2.4. Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	6200.0	6315.5	115.5	101.9
Нийт дүн	82600.0	83733.8	1133,8	101.37

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх оруулах орлогын төлөвлөгөөг 60,1 хувиар биелүүлж 39,9 хувиар тасарсан нь аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаа эрхлэлтийн орлогоос шалтгаалж. Аймагт төвлөрүүлэх орлогыг 98 хувиар биелүүлж 1,7 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан үл хөдлөх эд хөрөнгийн татвар, газрын төлбөрийн орлого дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2018.12.18-ний өдрийн 10/01 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 49900.0 мянга, татварын бус орлогыг 1500.0 мянга, ТБӨ-г 600,0 мянга нийт 51400.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 98139.1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 190.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Татварын орлого	49900.0	94080.5	44180.5	188.53
1.1. ИОТХ	4500.0	10843.6	6343.6	241.0
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	19000.0	24132.4	5132.4	127.1
1.4. Бууны татвар	2100.0	1590.0	-510.0	75.7
1.5. Улсын тэмдэгтийн хураамж	1200.0	4833.4	3633.4	402.8
1.6. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9000.0	9822.1	822.1	109.1
1.7. ТТАМАТөлбөр	300.0	300.0	0	100.0
1.8 Ан агнуур	13500.0	42258.8	28758.8	313.0
1.9 Нохойны татвар	300.0	300.0	0	100.0
2. Татварын бус орлого	1500.0	3428.6	1928.6	228.6
2.1 Хүү торгуулийн орлого	1500.0	3428.6	1928.6	228.6
ТБӨ	600.0	630.0	30.0	105.0

Нийт дүн	51400.0	98139.1	46739,1	190.93
----------	---------	---------	---------	--------

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2045565,1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1925343,0 мянган төгрөгийг урсгал зардалд, 120222,1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт 2045565,1 мянган төгрөгийн зардлын 1133646,3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 17392,2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 693144.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 73422.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 30941,7 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 97018.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1940686,8 төгрөг буюу 94,87 хувьтай байгаа нь цалингийн зардал 4028.1 мянга, ндш-зардал 322.7 мянга, тогтмол зардал 70.3 мянга, хангамж, бараа материалын зардал 3807.4 мянга, норматив зардал 2980.6 мянга, эд хогшил худалдан авах зардал 1219.4 мянга, томилолтын зардал 599.9 мянга, БГАУТХ-ийн зардал 32174.3 мянган төгрөгөөр тус тус зарцуулагдаагүй байгаа зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 10.Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	60,300.5	60,299.8	-0.70	100
Засаг даргын Тамгын газар	410,282.3	402,662.3	-7,620.00	98.1
Ерөнхий боловсролын сургууль	623,643.0	621,702.3	-1,940.70	103.9
Мандал бага сургууль			0.00	
Цэцэрлэг	249,705.6	248,169.1	-1,536.50	99.4
Соёлын төв	116,999.8	115,032.6	-1,967.20	101.4
Эрүүл мэндийн төв	375,852.0	370,328.2	-5,523.80	98.5
Сум хөгжүүлэх сан	88,559.8	60,490.0	-28,069.80	100
Орон нутгийн хөгжлийн сан	120,222.1	62,002.5	-58,219.60	100
Нийт дүн	2,045,565.1	1,940,686.8	-104,878.30	94.87

Хүснэгт 10.1 Төсвийн гүйцэтгэл зардлын ангилалаар /мянган төгрөг/

ангилал	Үзүүлэлт	батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь	хэтрэлт, хэмнэлт-
2.00	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,045,565.1	1,940,686.9	94.9	(104,878.2)
2101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,078,352.8	1,074,324.7	99.6	(4,028.1)
2102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,612.8	136,290.1	99.8	(322.7)
2103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,447.5	144,377.2	100.0	(70.3)
2104.00	Хангамж, бараа материалын зардал	72,842.9	69,035.5	94.8	(3,807.4)
2105.00	Нормативт зардал	109,965.3	106,984.7	97.3	(2,980.6)
2106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	86,327.2	85,107.8	98.6	(1,219.4)
2107.00	Томилолт, зочны зардал	18,381.2	17,781.3	96.7	(599.9)
2108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	142,115.6	109,941.3	77.4	(32,174.3)
2109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	69,324.4	67,905.8	98.0	(1,418.6)
2131.00	Засгийн газрын урсгал шилжүүлэг	39,947.4	39,910.0	99.9	(37.4)
213205.00	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,430.0	17,430.0	100.0	-
213209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,595.9	9,595.9	100.0	-
220001.00	Хөрөнгийн зардал	120,222.1	62,002.6	51.6	(58,219.5)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,045,565.1	1,938,606.2	94.8	(106,958.9)
131007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,133,646.3	1,127,269.6	99.4	(6,376.7)
132001.00	Орон нутгийн төсвөөс	693,144.7	675,521.4	97.5	(17,623.3)
132007.00	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	73,422.1	73,422.1	100.0	-
134002.00	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,392.2	14,773.3	84.9	(2,618.9)
1200041.00	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,341.7	47,619.7	156.9	17,278.0
1200042.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.0	-		
1200043.00	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	97,018.1	-		

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсөв: Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас ИТХ 500.0 мянга, ЗДТГ 43004.8 мянга, ЭМТ 83.4 мянга, Сургууль 26375.0 мянга, Соёлын төв 5082.2 мянга, нийт 75045.5 мянган төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	500,0	500,0
Засаг даргын Тамгын газар	43004.8	43004.8
Эрүүл мэндийн төв	83.4	83.4
Ерөнхий боловсролын сургууль	26375.0	26375.0
Соёлын төв	5082.2	5082.2
Нийт дүн	75045.5	75045.5

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Байхгүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баянбулаг сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 120 мэдээллийг хугацаанд нь, 34 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	9	2	1
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	49	11	

5	Тухай бүр	6	72	51	21	
6	Нийт	28	155	120	34	1

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Баянбулаг сумын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд гэрээт аудитор Даваабат хийж, аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянбулаг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

1. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянбулаг сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

